



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
БАЯНХОНГОР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2020 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 213

Номгон

**Засаг даргын үйл ажиллагааны  
хөтөлбөр батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-ийн “д”, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11.1, 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалтыг тус тус үндэслэн Баянхонгор сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Баянхонгор сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд оновчтой хуваарилан тусгаж, хөтөлбөрийн биелэлтийг хууль тогтоомжид заасан хугацаанд Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга /Ж.Мөнхсоёл/-д даалгасугай.

3. Засаг даргын сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, чиглэл өгч ажиллахыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.

ДАРГА М.Насанбат М.НАСАНБАТ



У.Насанбат  
Б.Мөнхсүх хэрэгжүүлэх  
Хамтсан ажиллагааг  
У.Насанбат  
М.Насанбат

7719028

**БАЯНХОНГОР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР**

**Нэг. “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын хүрээнд:**

**Зорилго 1.1. “Ковид-19” халдварт цар тахлаас урьдчилан сэргийлнэ.**

Зорилт 1.1.1. Сумын нутаг дэвсгэрт коронавирусийн халдварт цар тахалтай тэмцэх, хүн амыг “Ковид-19” вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, төрийн болон төрийн бус байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн үйл ажиллагааны бэлэн байдлыг хангана.

Зорилт 1.1.2. Хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоосон үед шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, оношлуур халдваргүйжүүлэх бодис, тоног төхөөрөмжийн хангалтыг тасралтгүй нэмэгдүүлж, хомсдол үүсэхээс сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж, нөөцийг бүрдүүлнэ.

Зорилт 1.1.3. Цахим орчин, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан, иргэдэд коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр эрүүл мэндийн мэдээлэл, зөвлөгөө, зөвлөмж, заавар зааварчилгааг хүргэх, сэрэмжлүүлэг мэдээллээр хангах ажлыг эрчимжүүлэн ажиллана.

Зорилт 1.1.4. “Ковид-19” вирусийн халдварын үеийн орон нутгийн эрсдэлийн үнэлгээг хийж, үр дүнг шийдвэр гаргах үйл ажиллагаанд ашиглах, эрсдэлийг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

**Хоёр. Хүний хөгжлийн бодлогын хүрээнд:**

**Зорилго 2.1. Эрүүл иргэн-Ирээдүйн үнэт зүйл**

Зорилт 2.1.1. Эрэгтэйчүүдэд чиглэсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж, тэдний эрүүл мэнддээ тавих анхаарлыг нэмэгдүүлж, төрөлжсөн үйлчилгээ үзүүлэх орчинг бүрдүүлж, “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Зорилт 2.1.2. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, халдварт болон халдварт бус өвчнийг бууруулна.

Зорилт 2.1.3. Иргэдийг зөв зохистой хооллох талаар сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулж, хүн амын дундах хоол хүнсний давс, чихэр, тосны хэрэглээг бууруулна.

Зорилт 2.1.4.Артерын даралт, биеийн жингийн индекс тодорхойлох, тоног төхөөрөмж суурилуулсан үйлчилгээний газруудын тоог нэмэгдүүлнэ.

Зорилт 2.1.5.Иргэдийн эрүүл мэндийн нэгдсэн мэдээллийн сантай болгоход мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж, оношлогоо, мэдээллийг дотооддоо цахимаар солилцдог болгоно.

Зорилт 2.1.6.Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эмч, ажиллагсдын ёс зүй, мэдлэг, ур чадвар, ажиллах орчин нөхцөлийг сайжруулж, орчин үеийн багаж тоног төхөөрөмжөөр хангана.

Зорилт 2.1.7.Өсвөр насны охидын жирэмслэлт, үр хөндөлт, төрөлтийг бууруулах, нөхөн үржихүйн эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.

Зорилт 2.1.8.Нотолгоонд суурилсан оношлогоо эмчилгээний уламжлалт болон орчин үеийн анагаах ухааны дэвшилтэт техник технологийг нэвтрүүлнэ.

## **Зорилго 2.2. Идэвхтэй амьдрал - Чийрэг иргэн**

Зорилт 2.2.1.Эрүүл, идэвхитэй амьдралын хэв маягийг сурталчлах, эрүүл аж төрөх ёс, нийтийн биеийн тамирыг дэмжих үйл ажиллагааг дэмжин хөгжүүлнэ.

Зорилт 2.2.2.Спорт заалнуудын ашиглалтыг сайжруулж, нийтийн биеийн тамир, дасгал хөдөлгөөнийг хөгжүүлж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

Зорилт 2.2.3.Иргэдэд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшил, спортын холбоо клубүүдийн үйл ажиллагааг дэмжинэ.

## **Зорилго 2.3. Боловсролын чанар-Хөгжлийн тулгуур**

Зорилт 2.3.1.Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын чанарыг сайжруулж, насан туршийн боловсролын үйлчилгээг өргөжүүлнэ.

Зорилт 2.3.2.Хүүхдэд ээлтэй, эрүүл, аюулгүй сургууль, цэцэрлэгийн орчин бүрдүүлнэ.

Зорилт 2.3.3.Тусгай хэрэгцээт боловсролын анги, бүлгийн хүртээмжийг нэмэгдүүлж, багшлах боловсон хүчнийг бэлтгэн, хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах боломжийг бүрдүүлнэ.

Зорилт 2.3.4.Сургуулийн дотуур байр, гал тогоо, спорт болон урлагийн заалны хүртээмжийг нэмэгдүүлж, сургууль бүрт "Үдийн хоол" олгох боломжийг бүрдүүлж, чанар хүртээмжийг сайжруулна.

Зорилт 2.3.5.Ерөнхий боловсролын сургуулиудын "Номын сан"-гийн үйл ажиллагааг өргөжүүлж, эрчимжүүлнэ.

Зорилт 2.3.6.Өсвөр насны хүүхдийн цахим донтолт түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна.

Зорилт 2.3.7. Хүүхэд, залуучуудын хөгжил, хамгаалалыг сайжруулж, Монгол өв соёл, зан заншлаа дээдэлсэн, бүтээлч, оюунлаг иргэн болж төлөвшихөд чиглэсэн нөлөөллийн олон талт арга хэмжээг зохион байгуулж, соён гэрээрүүлнэ.

Зорилт 2.3.8.Их, дээд сургууль, коллеж, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааг дэмжиж, суралцагчдын тоог нэмэгдүүлэх бодлого баримталж ажиллана.

#### **Зорилго 2.4. Орлоготой иргэн -Хариуцлагатай амьдрал**

Зорилт 2.4.1.Төр болон хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлж, хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого хэрэгжүүлнэ.

Зорилт 2.4.2.ЖДҮйлдвэрлэлийн бодлогыг, үйлдвэржилтийн нэгдсэн бодлоготой уялдуулж ЖДҮ, СХСангаар дамжуулан бага хүүтэй зээл олгож, бренд бүтээгдэхүүний борлуулалтын сүлжээг өргөтгөнө.

Зорилт 2.4.3.Жижиг, дунд бизнес эрхлэгчид болон гарааны бизнес эрхлэгчдийг бодлогоор дэмжиж орчин үеийн бизнесийн хэлбэрүүдийг нэвтрүүлнэ

Зорилт 2.4.4.Өрхийн оёдлын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

Зорилт 2.4.5.Хүүхэд бүрийг хадгаламжтай болгох “Хуримтлалтай хүүхэд” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

Зорилт 2.4.6.Хүн амын хөдөлмөр эрхлэх, мэдлэг, ур чадвар олгох сургалтуудыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран үе шаттай зохион байгуулж, ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлж ажиллана.

#### **Гурав. Амьдралын чанарыг сайжруулах бодлогын хүрээнд:**

##### **Зорилго 3.1. Халамжаас-Хөдөлмөрт**

Зорилт 3.1.1.Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтэд нийцсэн ажлын байрыг нэмэгдүүлнэ.

Зорилт 3.1.2.Зохион байгуулалттай ажлын байраар хангах үйлчилгээгээр дамжуулан тогтвортой ажлын байрыг нэмэгдүүлнэ.

Зорилт 3.1.3.Зорилтот бүлгийн өрхийн амьжиргааны түвшинг нэмэгдүүлнэ.

Зорилт 3.1.4.Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой, өрх толгойлсон эцэг, эхчүүд, 40-өөс дээш насныхан, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

### **Зорилго 3.2. Хонгорын иргэн-Хонгорын баялаг**

Зорилт 3.2.1. Гэр бүлийн тогтвортой байдлыг хангаж, гишүүдийн үүрэг хариуцлагыг сайжруулна.

Зорилт 3.2.2. Залуучуудын хөгжил, төлөвшилийг сайжруулж, нийгмийн идэвх, оролцоо, сайн дурын үйл ажиллагааг нэмэгдүүлсэн бодлого хэрэгжүүлнэ.

Зорилт 3.2.3. Хуримын ордныг ашиглалтад оруулж, гэр бүлд чиглэсэн үйлчилгээний төрлийг өргөжүүлж, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг сайжруулна.

Зорилт 3.2.4. Залуучуудын сэтгэл зүй, хөгжил, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд салбар бүрийн шилдэг залуучуудын хамтран хөтөлбөрт арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Зорилт 3.2.5. Угийн бичиг хөтлөх уламжлалыг сэргээн өрх бүр угийн бичиг хөтлөх, хүүхэд, залуучуудад түгээн дэлгэрүүлж хүн амын удмын санг хамгаалж, эрсдлээс урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлнэ.

Зорилт 3.2.6. Иргэдэд ээлтэй, эрүүл, аюулгүй амьдрах орчныг бий болгоно.

### **Зорилго 3.3. Хүүхдэд ээлтэй орон нутаг болно.**

Зорилт 3.3.1. Хүүхдийн хүчирхийлэл, ахуйн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсооход мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана.

Зорилт 3.3.2. Хүүхдийн хөгжил, хамгаалал, төлөвшилийг сайжруулж, эрүүл, аюулгүй орчинг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Зорилт 3.3.3. Хүүхэд, залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх орчин нөхцөлийг бий болгоно.

Зорилт 3.3.4. "Хөдөлмөр зуслан" байгуулж хүүхдүүдийг Монгол ахуйд сургана.

### **Зорилго 3.4. Соёлтой иргэн - Нийгмийг түүчээлнэ.**

Зорилт 3.4.1. Соёлын үйлчилгээгээр дамжуулан иргэдийг соён гэгээрүүлж, биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулж өсвөр үе, залуучуудад сурталчлан таниулна.

Зорилт 3.4.2. Монгол ахуй, ёс заншил, өв уламжлалыг хүүхэд бүрт өвлүүлэхэд эцэг, эхийн үүрэг оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлнэ.

Зорилт 3.4.3. Уран бүтээлчдийг Улсын болон Олон Улсын тэмцээн, наадамд оролцоход дэмжлэг үзүүлнэ.

Зорилт 3.4.4."Соёлтой-Хонгорчууд" хөтөлбөр хэрэгжүүлнэ.

Зорилт 3.4.7.Соёлын хандлагыг өөрчлөх замаар хувь хүн, гэр бүл, байгууллагын соёлын дархлааг сайжруулж "Бүх нийтийн соёлын боловсрол" арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Зорилт 3.4.8.Иргэн бүрт ном унших дадал, хэвшлийг нэмэгдүүлж, номын сангийн үйлчилгээг өргөжүүлж, үйл ажиллагааг сайжруулна

### **Дөрөв. Эдийн засгийн бодлогын хүрээнд:**

#### **Зорилго 4.1. Эдийн засгийн чадварыг дээшлүүлнэ.**

Зорилт 4.1.1.Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэхэд сургалт сурталчилгаа, нөлөөллийн олон талт арга хэмжээ зохион байгуулна.

Зорилт 4.1.2. Эрүүл хөрс - Эрүүл хүнс - Эко үйлдвэрлэлийг дэмжинэ.

Зорилт 4.1.3.Орон нутгийн онцлогт тохирсон үйлдвэрлэлүүдийг хөгжүүлнэ.

Зорилт 4.1.4.Сумын хөгжилд инноваци шингэсэн үйлдвэрлэл, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.

#### **Зорилго 4.2. Хөнгөн аж үйлдвэрийг хөгжүүлнэ.**

Зорилт 4.2.1.ХАА-ын хоршоодыг кластерийн системээр хөгжүүлнэ

Зорилт 4.2.2.Газар тариалан эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж, тариалалт, ургац хураалтыг нэмэгдүүлнэ.

Зорилт 4.2.3.Төмс, хүнсний ногооны нөөцийн хангамжийг нэмэгдүүлж, тэжээлийн ургамал тариалах иргэн, аж ахуйн нэгжийг дэмжинэ.

Зорилт 4.2.4.Малчид өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэхэд бодлогоор дэмжинэ.

Зорилт 4.2.5.Бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэн хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг үе шаттай зохион байгуулна.

Зорилт 4.2.6."Монгол мал" үндэсний хөтөлбөрийн 2 дахь үе шатыг хэрэгжүүлж, бэлчээрийн менежментэд нийцсэн мал аж ахуйг хөгжүүлж, чанар, ашиг шимийг дээшлүүлнэ.

Зорилт 4.2.7.Мал эмнэлгийн аж ахуйн нэгжийг чадавхжуулж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн эрүүл бүсээ хадгална.

#### **Зорилго 4.3. Аялал жуулчлал хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлж, орлого нэмэгдүүлнэ.**

Зорилт 4.3.1.Орон нутгийн онцлог, түүхэн дурсгалт, үзэсгэлэнт газрууд болон уламжлалт ахуй соёлд түшиглэн аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлж, орлого нэмэгдүүлнэ.

Зорилт 4.3.2. Аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, иргэдэд хүү багатай, хөнгөлөлттэй зээлд хамруулан үйл ажиллагааг нь өргөжүүлэх чиглэлээр дэмжинэ.

Зорилт 4.3.2. Дотоод, гадаадын жуулчдын аялах, амрах нөхцөлийг төр, хувийн хэвшлийн оролцоотойгоор бий болгоно.

Зорилт 4.3.3. Түйн голын ай сав дагуу амрах, аялах, зугаалах орчин нөхцөл бий болгож, тохижуулна.

#### **Зорилго 4.4. Ээлтэй төлөвлөлт - Эрсдэлгүй амьдрал.**

Зорилт 4.4.1. Сумын хилийн цэст нэмэлт өөрчлөлт оруулна.

Зорилт 4.4.2. Сумын инженерийн дэд бүтцийг сайжруулж, иргэдийг ая тухтай тохилог орчинд амьдрах нөхцөлөөр хангана.

Зорилт 4.4.3. Орон сууцны /орлогод нийцсэн, түрээсийн, ногоон / хангамжийг 10-20 хувиар нэмэгдүүлнэ.

Зорилт 4.4.4. Сургууль, цэцэрлэг, дотуур байр, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн барилгад их засвар хийх, шинэчлэн барина.

Зорилт 4.4.5. Сургууль, цэцэрлэг, дотуур байр, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн ус хангамж, ариутгах татуургыг стандартад нийцүүлнэ.

Зорилт 4.4.6. Цэвэр, бохир усны шугам сүлжээг шинэчилж, нэмэгдүүлнэ

Зорилт 4.4.7. Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу гэр хороололд эко нойл болон шинэ технологи нэвтрүүлнэ.

Зорилт 4.4.8. Сумын гэр хорооллын айл өрхийн 20 хувийг стандартын шаардлага хангасан муу усны нүхтэй болгоно.

Зорилт 4.4.9. Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны барилгууд болон гэр хорооллыг хэсэгчлэн дахин төлөвлөлтөд оруулж, орон сууцжуулна.

Зорилт 4.4.10. Ахмад настны амралт чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, хөгжих цэцэрлэгт хүрээлэнг байгуулна.

Зорилт 4.4.11. Нутгийн өөрөө удирдах байгууллага болон Нутгийн захиргааны байгууллага, "Цэвэр хот" ОНӨААТҮГ, "Хот тохижилт" ОНӨААТҮГ-ын барилгын ажлын зураг, төсөв хийлгэнэ.

Зорилт 4.4.12. Түүх угсаатны зүйн музейн шинэ барилгын зураг, төсвийг хийлгэж барилгын ажлыг эхлүүлнэ.

Зорилт 4.4.13. Усан бассейн бүхий спорт цогцолборын барилгын ажлыг дуусгана.



- Зорилт 4.4.14. Сумын хүүхэд, залуучуудын соёлын ордонь зураг, төсвийг хийлгэж, ашиглалтанд оруулна.
- Зорилт 4.4.15. Өвлийн спортын цогцолбортой болно.
- Зорилт 4.8.16. Кино театрттай болгоно.
- Зорилт 4.4.17. Сэргээн засах сувилал байгуулна.
- Зорилт 4.4.18. Жаргалант паркад Хүүхдийн парк байгуулна.
- Зорилт 4.4.19. Нүүрсний уурхайг түшиглэн шахмал түлшний үйлдвэр байгуулна.
- Зорилт 4.4.20. Барилгын чулуун материалын үйлдвэр байгуулна.
- Зорилт 4.4.21. Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр байгуулна.
- Зорилт 4.4.22. Махны үйлдвэр, мал нядалгааны цэг байгуулна.
- Зорилт 4.4.23. Хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрийн ажлыг эхлүүлнэ.
- Зорилт 4.4.24. Түйн голын гарамд төмөр бетонон гүүр барина.
- Зорилт 4.4.25. Сумын төвд 10-15 км авто зам барина.
- Зорилт 4.4.26. Сумын хатуу хучилттай авто болон явган замд засвар, арчлалт хийх, шинэчлэх, тэмдэг тэмдэглэгээ тавина.
- Зорилт 4.4.27. Нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлж, нислэгийн тоог нэмэгдүүлэх, нисэх буудлын үйл ажиллагааг Олон Улсын стандартад хүргэнэ.
- Зорилт 4.4.28. Дулааны станцыг барьж, шугамуудыг холбоно.
- Зорилт 4.4.29. Сумын ус хангамжийн төв магистраль шугамыг хэсэгчилэн солино.
- Зорилт 4.4.30. Сумын цэвэрлэх байгууламжийг шинэчлэн байгуулна.
- Зорилт 4.4.31. Цэвэрлэх байгууламжаас гарсан саарал усыг ашиглах судалгаа шинжилгээний ажлыг хийнэ.
- Зорилт 4.4.32. Цахилгаан дамжуулах 110/35/6кВ-ын Баянхонгор дэд станцын суурилагдсан хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.
- Зорилт 4.4.33. Сумын гудамж, зам талбайг үе шаттайгаар камержуулж, гэрэлтүүлэгтэй болгоно.
- Зорилт 4.4.34. СӨХолбоог бий болгоно.
- Зорилт 4.4.35. Шинэ суурьшлын бүсэд бага оврын цэвэрлэх байгууламжийн ажлыг эхлүүлнэ.
- Зорилт 4.4.36. Сумын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу "Хонгор 1000" хорооллын ажлыг хийж дуусгана.



Зорилт 4.4.37.Сумын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу "Эрдэнэмандал" хорооллыг дахин төлөвлөлтөнд орууна.

Зорилт 4.4.38.Залуус хороолол болон шинэ суурьшлийн бүсийн инженерийн дэд бүтцийг шийдэн айл өрхийг суурьшуулж, ногоон байгууламж, гэрэлтүүлэгтэй болгох, явган зам, дугуйн зам барина.

Зорилт 4.4.39.Сумын "Цахир" багт баригдаж буй багийн хөгжлийн төвийг ашиглалтад оруулж багийн иргэдэд төрийн үйлчилгээг нэг дороос авах "Жишиг төв" болгоно.

Зорилт 4.4.40.Иргэдэд эко болон бага, дунд оврын автобусаар нийтийн тээврийн үйлчилгээг үзүүлнэ.

Зорилт 4.4.41.Сумын ундны усны эх үүсвэрийг нэмэгдүүлэх, гэр хороолол болон шинэ суурьшлын бүсэд ухаалаг усан сан бий болгоно.

Зорилт 4.4.42.Сумын төвийн баруун талд улсын чанартай зам дагуу болон Арван мянгатын ногоон зурвасны орчим, Эрдэнэцогтын гарамны бетонон гүүрийг түшиглэн хяналт шалгалтын цэг байгуулна

#### **Тав. Засаглалын бодлогын хүрээнд:**

**Зорилго 5.1.**Мэдээллийн технологид тулгуурлан төрийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй, хариуцлагатай хүргэх орчин нөхцөлийг бүрдүүлж, чадварлаг, ёс зүйтэй, шударга, ил тод байдлыг хангасан, чадавхуйн зарчмыг төлөвшүүлсэн төрийн албыг бэхжүүлнэ.

Зорилт 5.1.1.Төрийн байгууллагуудын шударга, ил тод байдлыг нэмэгдүүлнэ.

5.1.2. Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангана.

Зорилт 5.1.3.Төрийн байгууллагын ажиллах орчин нөхцөл, техник, технологийг сайжруулна.

Зорилт 5.1.4.Чадварлаг, ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлнэ.

Зорилт 5.1.5. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд, олон нийт хяналт тавих, оролцоог хангах нөхцөлийг нэвтрүүлнэ.

Зорилт 5.1.6.Төр болон хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулж, хувийн хэвшлийн нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлнэ.

Зорилт 5.1.7.Төрийн ажил үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, үйл ажиллагааны зардлыг бууруулахад чиглэсэн цахим системийг нэвтрүүлнэ.

Зорилт 5.1.8.Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудаар гүйцэтгүүлж гурван талт түншлэлийг оновчтой, үр дүнтэй нэвтрүүлнэ.

Зорилт 5.1.9. Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагын ажилтнуудын санхүү бүртгэлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлнэ.

Зорилт 5.1.10. Архив, албан хэрэг хөтлөлтийн болон баримтын хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, нягтруулсан тавиур шүүгээтэй болгох, камерийн хяналтад шилжүүлж, аюулгүй байдлыг хангана.

Зорилт 5.1.11.Орон нутгийн төсвийг хэмнэлттэй, үр ашигтай төлөвлөн төсвийн орлого бүрдүүлэлтийг сайжруулж, санхүүгийн алдаа зөрчлийг бууруулах, салбарын боловсон хүчний мэдлэг, чадварыг дээшлүүлэх, төсвийн ил тод байдлыг хангах зорилгоор "Тунгалаг санхүү" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

Зорилт 5.1.12.Иргэдийн санал хүсэлтэд тулгуурлан орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг үр ашигтай, төлөвлөн зарцуулна.

Зорилт 5.1.13.Мэдээллийн дэвшилтэт технологийн шинэчлэлийг төрийн үйл ажиллагаанд үе шаттайгаар нэвтрүүлж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын мэдээллийн аюулгүй байдлыг хангах цогц үйлчилгээг нэвтрүүлнэ.

Зорилт 5.1.14.Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн эрсдэлийн сан байгуулна.

Зорилт 5.1.15.Хөдөлмөрийн зах зээлийн судалгааг хийж, эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн бодлого хэрэгжүүлнэ.

Зорилт 5.1.16.Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг даатгалын үйлчилгээнд хамруулж, нийгмийн баталгааг хангана.

Зорилт 5.1.17.Гадаадад хөдөлмөр эрхэлж байгаа болон мэргэжил эзэмшиж буй иргэдийн мэдээллийн сан үүсгэж тэднийг орон нутагтаа хөдөлмөрлөх, бизнес эрхлэх, ажиллахад дэмжлэг үзүүлнэ.

Зорилт 5.1.18.Эцэг, эхийн үүрэг оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлнэ.

Зорилт 5.1.19. Гэр бүлд зөвлөгөө өгөх үйлчилгээг боловсронгуй болгож, гэр бүл төлөвлөлтийг сайжруулсан бодлого боловсруулж, хэрэгжүүлнэ.

Зорилт 5.1.20.Газар өмчлөлийг нэмэгдүүлнэ.

Зорилт 5.1.21.Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх тогтолцоог бэхжүүлж, иргэдэд эрх зүйн харилцаанд бие даан оролцох чадварыг боломжит хэлбэрээр нэмэгдүүлнэ.

Зорилт 5.1.22.Төрийн байгууллагын архивын баримтын цахим санд шилжилтийг эрчимжүүлнэ.

Зорилт 5.1.23.Төрийн байгууллагын Архив бичиг хэргийн ажилтнуудын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх, мэргэжилтэй боловсон хүчнээр хангана.

**Зургаа. Ногоон хөгжлийн бодлогын хүрээнд:**

**Зорилго 6.1. Сумын байгаль орчны тэнцвэртэй байдлыг хангана.**

Зорилт 6.1.1.Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, байгальд ээлтэй, хэмнэлттэй, үр ашигтай дэвшилтэт технологи нэвтрүүлэн, уур амьсгалын өөрчлөлтийг саармагжуулах, дасан зохицох чадавхыг нэмэгдүүлнэ.

Зорилт 6.1.2.Иргэдийн 20 хувьд ногоон хөгжил, тогтвортой хөгжлийн боловсрол олгоно.

Зорилт 6.1.3."Хамгаалах-ашиглах" зарчмаар нутгийн иргэдийн оролцоонд тулгуурлаж байгаль орчныг хамгаална.

Зорилт 6.1.4.Орон нутаг өөрийн нөөц боломжоор 10 мянган мод тарин, усалгааны системтэй болгож, ойн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.

Зорилт 6.1.5.Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн хяналтыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Зорилт 6.1.6.Зэрлэг болон ховордсон ан амьтдыг хамгаалах, өвс, тэжээлийн хомсдлоос урьдчилан сэргийлэх, амьдрах орчныг сайжруулах чиглэлээр зэрлэг амьтны байршил бүхий газруудад биотехникийн арга хэмжээ авна.

Зорилт 6.1.7.Түйн голын Цагаан бургасыг орон нутгийн тусгай хамгаалалтанд авч, Цагаан эрвээхэй бусад хортон шавьжийг устгах, хамгаалах, нөхөн сэргээх, нэмэгдүүлнэ.

Зорилт 6.1.8.Сумын Эрдэнэмандал хайрханы орчныг цэцэрлэгжүүлж арцат ногоон бүс болгох ажлыг эхлүүлнэ.

Зорилт 6.1.9.Шарил чандарлах орчин үеийн технологийг нэвтрүүлнэ.

Зорилт 6.1.10.Усны хуримтлал, ус хангамжийг нэмэгдүүлж, усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалах, зохистой ашиглах нэгдсэн менежментийг хэрэгжүүлнэ.

Зорилт 6.1.11.Хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усаар хангана.

Зорилт 6.1.12.Хог хаягдалын менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.

Зорилт 6.1.13.Агаар, хөрс, орчин, усны бохирдлыг бууруулах хөтөлбөрийг шинэчилж хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, Олон Улсын төсөл хөтөлбөрийн байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

Зорилт 6.1.14. Уурын зуухнуудын стандарт шаардлагыг хангуулж, агаар, хөрсний бохирдлыг бууруулна.

**Долоо. Амар тайван, аюулгүй нийгмийг бий болгох бодлогын хүрээнд:**

**Зорилго 7.1.Иргэдийн аюулгүй байдлыг хангах орчин нөхцөлийг сайжруулна.**

Зорилт 7.1.1.Сумын хэмжээнд бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулахад мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллана.

Зорилт 7.1.2.Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг тогтоох түүнээс урьдчилан сэргийлэх, гаралтыг бууруулна.

Зорилт 7.1.3.Согтуугаар үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулна.

Зорилт 7.1.4.Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчил, ахуйн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, гаралтыг бууруулахад мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана.

Зорилт 7.1.5.Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн гаралтыг бууруулна.

Зорилт 7.1.6.Мал хулгайлах гэмт хэргийн гаралтыг бууруулна.